



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5/05

Хэрлэн сум

**Э.Сувд-Эрдэнийг шилжүүлэн
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоол, 2023 оны 378 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын 2.1 дэх хэсэг, Засгийн газрын "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", 2022 оны "Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 489 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" Б/46 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Залуучуудын хөгжлийн төвийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд ажиллуулах шийдвэр гарсантай холбогдуулан Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Энхбаатарын Сувд-Эрдэнийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст шилжүүлэн томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Н.Зоригтбаатар	Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Ш.Эрдэнэжаргал	Хүний нөөц, дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн
	Ж.Цэнджав	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Х.Баярбаатар	Нягтлан бодогчийн үүргийг тор орлон гүйцэтгэгч

2.

С.Чулуунцэцэг Няравын үүргийг түр орлон гүйцэтгэгч

3.Э.Сувд-Эрдэний цалинг ТЗ-7 зэрэглэлээр тогтоон, үндсэн цалинг 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 7 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Х.Баярбаатар)-д зөвшөөрсүгэй.

4.Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэн, холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг Э.Сувд-Эрдэнэд үүрэг болгосугай.

5.Э.Сувд-Эрдэний ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлж, холбогдох эд хөрөнгийг бүртгэлжүүлэн авахыг комиссын бүрэлдэхүүн (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ДАРГА  Ж.ГАНТУЛГА